

Танай сумыг зорин ирэх иргэдэд ямар боломж, нөхцөл олгох вэ?

- Төмс, хүнсний ногоо тариалах эзэмшлийн талбайг олгох
- Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах үүднээс сумын төвд орон сууцаар хангах
- Тухайн орон нутагт ажилласан нэмэгдэл 20%-ийг тооцож орон нутгаас олгох
- Шинэ суурьшлын бүсэд өмчлөлийн газрыг нэн түрүүнд олгох, эзэмшлийн газар авахад давуу эрх олгох
- Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, төсөл хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх

Түшиг сумын хэмжээнд төрийн захиргааны 8 мэргэжилтэй, их эмч, сувилагч, химийн багш, математикийн багш, номын санч, бүжгийн багш гэсэн орон тоо дутагдалтай байна.



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ:

Атар газар эзэмших хөдөлгөөн Монгол орон даяар эрчимтэй өрнөж байсан 1950-иад оны сүүлээр БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1959 оны 4-р сарын 22-ны өдрийн 156-р тогтоолоор Зэлтэрийн САА-г байгуулжээ.

Тус сум нь баруун талаараа Булган аймгийн Сэлэнгэ сумтай, хойд талаараа ОХУ-ын Буриад улсын Джида районтой, урд талаараа Цагааннуур сумтай, зүүн талаараа Сүхбаатар сумтай хиллэдэг.



ТҮШИГ СУМ



95154248



<http://tushig.se.gov.mn/>



Нийслэл Улаанбаатар хотоос 450 км, аймгийн төв Сүхбаатар хотоос 135 км зайд оршдог сум, аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбогдсон.

Сэлэнгэ аймгийн Түшиг сум нь газар тариалангийн бүс нутаг бөгөөд эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр Халимаг, Ангус, Талын улаан мах сүүний чиглэлээр үхэр сүргээ эрчимжүүлэн хөгжүүлж байна. Түшиг сум нь байгаль цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай бөгөөд зуны болон өвлийн аялал жуулчлал, морин аяллыг хөгжүүлэх боломжтой.

Манай сум нь хойд талаараа ОХУ-ын Буриад улстай хиллэдэг бөгөөд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын боомтын сэргэлтийн хүрээнд Зэлтэр хилийн боомт ашиглалтад орсноор эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн чиглэлд Джида аймагтай хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж бүрдэнэ. Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэх, оюутан-сурагч солилцоо, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх боломж бүрдэнэ.



ТҮШИГ СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Түшиг сумын хөгжлийн гарц нь хүний хөгжил бөгөөд хүн амын тогтвортой өсөлтийг хангах, орон нутгийн хөгжлийг шинэ шатанд гаргах ажлын хүрээнд орон нутагт шилжин ирэх иргэдийг ажлын байраар хангах, өрхийг

жижиг дунд бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна.

Орон нутгийн хэмжээнд өрхийн үйлдвэрлэлийн хувьд жимс, жимсгэнэ болон утсан болон лаазалсан загасан хүнс гаргахаас гадна эрчимжсэн үхрийн аж ахуйг хөгжүүлэх, хүлэмжийн аж ахуйг эрхлэх нөхцөл боломж бүрдсэн.



ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ БОЛОН ХИЙГДЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ:

Хот хөдөөгийн сэргэлтийн хувьд сумын хэмжээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Шинэ суурьшлын бүсийг тогтоож, төлөвлөлтийг хийх
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн өсөлтийг хангаж, тариалалтын талбайг нэмэгдүүлэх
- Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах
- Хүлэмжийн аж ахуй, тэр дундаа өвлийн хүлэмжийг аж ахуйг хөгжүүлэх

Дулааны шугамын өргөтгөлийн ажлыг хийж төвийн А зэрэглэлийн айл өрхийг төвийн халаалтад холбох бүрэн боломжтой.

